Тавин долоон жил болтол чилэл үгүй хөхөхөд эхийн хөх дунд орж, хөвгүүний унд тэр цагт ханан номын ёсоор суувай. Багмани хатан Сайн галавын мянган бурханд мянган бүхэл хив барьж баримад гүйцээж, зуун алтан мянган бүхэл хүж барьж бурханы сэтгэлийг хангав. Тэр баяр хоёулан Бодолын уулын дэргэд одож мөнгөн шилт, алтан хот суваргыг байгуулан суувай.

Аюу бодьсад дахин зарлиг болов.”Аяа, хатан эжий минь та Бодолын уулын дэргэд мөнгөн суваргатаа амар мэнд суугтун. Би доорд Замбуу тивийн оронд номын увидас шингээгээд ирсү” гэж зарлиг болов.

Гагц төрсөн бодьсад минь цааш бурхан болох үйлэнд чинь зэтгэр бүү үйлдсүгэй би хэдий боловч өдий тотогш бол юу суугаад ирээ. Хатан эжийхээ хамаг хүслийг ханатал суув. Аюу бодьсад нэгэн үе алтан тогос болон Замбуу тив өөд одсонд Багмани хатан мөнгөн шил сүүлтэй алтан жигүүртэй бор эрээн тогтюур нэрт харцгай болон хувилаад, тэнгэр газрын завсарт ширээ тогтоон гурван хоног болтол амтат сүүгээн хөхүүлэн суув.

“Гагцхүү төрсөн бодьсад минь чамайгаан аль өдөр ирэх билээ гэж санаж суух би, над дор хоног болзож өгөн үйлд” гэв. “Хатан эжий минь Бодолийн дэргэдэх мөнгөн суваргатаа суугтун, би арван таван хоног болтол ирэхши би” гэж зарлиг болов. Багмани хатан өөрийн хийдэд зорьж явахуйд “Там гэгч оронд ямар үйл хийсэн амьтан тамаас гэтэлж байдаг аж гэж тамд орёё гэж явна гэхүл нэгэн гадны түмэн алд харанхуй хар тамд түмэн хатан хүмүүн ирж унав.

Багмани хатан тэр тамын аман түмэнг номын хүчээр там дахь түмэн хатан хүнийг гэтэлгэж, Бодолын ууланд төрүүлвэй. Тэр эрт амьд цагтаа нэгэн ламын мацаг маань тэргүүтнийг нэгэн ламын

зарлигийг сонссонд тэд зарлигийг мартаад хоорондоо хов хутган ёсгүй үг хэлэлцсэний тулд үхээд тамд унасаны учир тэр буй.

Багмани хатан өөрийн оронд суухуйд “Гагц бодьсад минь ирэгч болзооны өдөр билээ” гэж гэнэт санан харж суутал Аюу бодьсад Замбуу тивд одон ерөөлийнхээ хоёрыг сайн илэрхий номлосонд ном үгүй амьтныг номтой болгож, үхсэн амьтныг сайн сайхан оронд гаргаж явсан амьтан энх жаргалантай болов. Эх хөвгүүн бүрэн нийлэлдэж хүслээ хангав.

Гурван зургаан хоногт хутаг оршуул бай. Нэг цагийн үе болтол суугаад Сэра, Брайвун, Галдан гомон гурван зуун жаран зургаан үүднээ эрхшээлийг оноё гээд дээдийн дээдэд суудаг ламд хийд баригч газрын учир айлтгая гээд дээд оронд зорин өөд болон явтал хоёр хийдийн хооронд нэгэн шиварагч лам хүмүүн идэх үгүйгээс харангалан, ангахуй умдаан үгүй цөлдөн үхэдхийж хэвттэл Багмани хатан тэр ламыг өвөр дээрээ авч аман дахь шороог хэлээрээ арчин юмчин цагаан хөхөөн гаргаж амтат сүүгээн хөхүүлэн тэнхээгээд эх хөвгүүн хоёулан дөрвөн мөчний махыг барагдтал сэлэн сэлэн үүрчих хийдийн дэргэд хүргэж орхивой.

Түүнээс цааш явж ламыг ламд айлтгав. “Хязгаар завсар оронд хууль бий. Хийд барих газрын учир айлтгая” гэж ирэв, би” гэж зарлиг болсонд лам зарлиг болвой. “Зургааны эх болсон Дарь эх үүдний хөрмөл хар уулыг даваад, түүний цаана Бодолын шонх цагаан дээр гарахуйяа газрын агуу их хөтөл их мөнгөн дэлтэй мэт харагдаж байх бий. Түүнд иртэл гантиг ууссан өөдөө алтан мөнгөөр буцлан байх булаг буй.

Тэр булгийн эхэнд алтан мод мөнгөн мөчиртэй галбарбаасан мод эрдэнээр чимсэн навч бүр нь нижгээд бурханы орон бүтсэн байх буй. Аяа Багмани хатан таны хийд түүнд тогтох буй за” гэж зарлиг болов.

Ламын зарлигийг сонсоод хөвгүүн эх хоёулан явж үүдний хөрмөл хар уулыг даваад Бодолын шонх цагаан хөтөл дээр гараад Ламын зарлигаар газар үзэгдэхүй тэр эх болзооны газарт хүрээд эх хүү хоёр Бодолын эхэнд өлзий оршуулан суугаад өглөөний нарнаар нэгэн хийд эхлэн барихад үдэш хүргэлгүй алтан хийд тогтоон барив. Тэр хоёр хийдийн гэгээн гэрэл хоёр нь наян найман жилийн газраас харагдаж байв.

Шөнө нойрын цагт Аюу бодьсад нойрсоод босон гэхүл мөнгөн

сүүлтэй. алтан дэлтэй, болд тууртай, наян найман өнгийн биетэй, навч хар морь алтан аргамжаар аргамжтай, өвсний толгойд туруугаа хүргэлгүй бүжиглэн дүүлэн аялахаар цэрвэн найган байв. Аюу бодьсад үзээд, эхдээ зарлиг болов.

“Аяа, Багмани хатан эжий минь, манайд морь үгүй билүү, Энэ юун буй, сайхан үзэсгэлэнт морь буй. Гагц төрсөн бодьсад минь ухаандаа шинжилж мэд. Нүглийн хүчээр ирсэн морь биш байна аа, буяны нөхөр садан болох морь гэж зарлиг болсонд Аюу бодьсад тэр морийг хүлэглэж нэгэн бээрийн газарт явж сургаад, эрлэгийн оронд наян найман жил болж хүрэх хол газарт буй. Тэр навч хар мориор эрлэгийн оронд өдрийн гурав хүрч түмэн харанхуй хар тамаар төрсөн амьтныг хов хоосон болтол гэтэлгээд хийддээ өдрийн гурав хүрч харьж ирж байв.

Эрлэг хааны арслан тэргүүтэн хөвгүүн хан эцэгтээн ийн хэмээн айлтгав. Урьд там өдрийн гурав дүүрдэг билээ. Одоо өдрийн гурав хоосон болж байна. Хэн нэрт бодьсад гэтэлгэж байна гэж айлтгасанд Эрлэг хаан зуун найман асарт хотын балгадын орой дээр гараад умар харж үнэнхүү гэхүүнээ алтан мөнгөн газар хийдийн гэрэл, наран ургасан мэт үзэгдэв. Түүнийг хэнийг ч Цагаан Дарь эхийн хөвгүүн тахин байна. Зургаан зүйлийн эх болсон Дарь эх амьтан бүгдийг туслан үйлдэхдээ “Миний үйл бүгдийг өршөөн үйлд” гэжес ес наманчилан байв.

Эрлэг хаан арслан тэргүүтэн хөвгүүндээ захив. “Цагаан Дарь эх энэхүү гэгээнд мянган бүхэл хив барьж, барамид гүйцээ, зуун алтан мянган бүхэл хүж барьж хамрын үнэрийг ханга” гээд түмэнл уус туулгаж илгээв. Арслангийн тэргүүт нэгэн хөвгүүн нэгэн нэгэн сард нэгэн луус унаж явсаар, түмэн сар болж хүрч ирсэнд, хив хүж тэргүүтнийг хоёр хийдийн дэргэд хүргэж орхиод явна гэхүлээ аргамжилтай байх навч хар морийг хулгайлж унан шөнө дөлөөр хүлэглэн өөрийн гэрт одсонд Эрлэг хаан эцэгтээ үзүүлэх үгүй тэр навч хар морийг авч одоод халуун тамд орхив.

Маргаад нь халуун тамд түлэн үхэв үү гээд үзнэ гэхүүнэ халуун тамд халуунаар энэлсэн амьтанд арван хоёр ахуй сайхны сэрүүн сайхан салхи оруулаад халуунаар энэлсэн амьтан бүгдээр баясгалан болж байв.

Тэр морийг гаргаад хүйтэн тамд орхив. Маргаад нь хүйтэн там дахь амьтан хөрөн линхуа энэлсэн амьтанд арван хоёр ахуй сайхан

халуун нарны элч гэрэл оруулан байв.

Хүйтнээр энэлсэн амьтан бүгдээр тамаас гэтэлгээд түмэн харанхуй хар тамаар төрсөн амьтныг хов хоосон болтол гэтэлгээд огторгуйгаар халин цэрвэн гарсанд дээдийн дээдэд суудаг ламын ламд зарлиг болохдоо Цагаан Дара эхийн хөвгүүн Аюугийн ойр орчныхоо орон байхуйд Галдан тэнгэрийн хүүхэн Зандан төгссөн эх дагины хувилгааныг хатан болохунаа үхэл зовлон болохгүй гэсэн зарлигаар огторгуйд гарсанд Галдан тэнгэрийн хүүхэн Зандан төгссөн эх дагины дүр хувилгаан эх дагинасаа дагуулж амьтны тусад өөд болж явтал наян найман өнгийн биетэй навч хар морь өвсний толгойд туруугаа хүргэл үгүй бүжиглэн тушаалан аялахаар цэрвэн найгалзан явтал Зандан дагина зарлиг болруун болов.

“Зуун найман ухаанд мэргэжсэн Янсуг улагчин, юун сайхан үзэсгэлэнт морь буй, түүнийг над барьж аваач. Би унаж сурган талбия” гэв. “Мянга таван зуун ухаанд мэргэжсэн Зандан төгссөн эх дагинын хувилгаан минь ухаандаа шинжилж мэд.

Энэ адгуусан төрөлхтөн биш, хүмүүний төрөлхтөн байнам. Үүнийг унах учир үгүй” гэж айлтгасанд ер Зандангийн дур сэтгэл булаачихуй үзэсгэлэнтийн тул надад барьж аваач.

Би унан сургаад тавъя, би” гэж зарлиг болсонд Янсуг улагчин барьсу гэхүнээ мөнгөн шаахайдаан ороолдон баригдав. Зандан дагина тэр морийг барьж хүлэглэж нэгэн бээр газарт бүжиглэн тоглов.

Хоёр бээрийн газар болоход тэнгэр газар хоёрын завсарт орон халин цэрвэн үгүй болсоныг үзсэн Янсуг улаачин гэдрэгээ харан Галдан тэнгэр эцэг, алтан Чойжин барайбун хатан ээждээн хэлээд Нармаа тэнгэр ах, найман түмэн шавь нартаа хэлээд, тэр биеэрээ Зандан дагиныг гүйцэн ирэв.

“Мянган таван зуун ухаанд мэргэжсэн Зандан эх дагинын хувилгаан минь! Галдан тэнгэр, Алтан Чойжин барайбун хатан ээжээ орхиж, Нармаа тэнгэр ахаа орхиж, найман түмэн шавь нараа орхиж, чи минь хаана одох болмуй” хэмээн дуудсанд “Зуун найман ухаанд мэргэжсэн Янсуг улаачин минь! Ухаандаа, намайг Цагаан Дарь эхийн хөвгүүн Аюуд хатан болохунаа үхэл зовлон үгүй болж шажин дэлгэр! хэмээсэн зарлигаар явнай би.

Галдан тэнгэр эцэг, алтан Чойжин барайбун хатан ээжид минь хэлтүгэй. Нарма тэнгэр ах, найман түмэн шавь нарт минь хэл!” гээд

хариулав. Зандан дагинийн зарлигийг тэд бүгдээр тэнгэрийн орныг долгиулан үйлдсэнд “Зандан төгссөн эх дагинын хувилгаан минь хан эцэг, хатан эжий, хамаг бүгдийг орхиж ганцаар хаана одсон буй” хэмээн уйлалдав.

Цагаан Дарь эхийн Аюу бодьсад Зандан төгссөн эх дагинын хувилгаан хоёулан сэтгэл найралдан, үхэл зовлон үгүй болж, энх жаргалан мөнх нас гурван үе дэлгэрч, урт наслан суув.

Тэр тивийн орноо жаргалан суусанд буй Аюу бодьсадын алтан эрдэнээр бүтсэн орд харшийн дээр гурван голтой учирсан зул мэт байхад Аюу бодьсад өглөө босоод навч хар морь үгүйг үзээд алтан орд харшийн дээр гаран гүйхнээ гурван цагийн бурхан багш гурван мянган шавь нараар хүрээлүүлэн суувай.

Аюу бодьсад бурхан багшийн дэргэд очсонд бурхан багш зарлиг болов. “Аюу бодьсад чи мэдэв үү. Эдүгээ хоёр хийдийн хооронд бодь сэтгэлээр идэх уух үгүй цөлдөн үхэдхийж хэвттэл эх чинь намайг өвөр дээрээ авч аман дахь шороог минь хэлээрээ арчин юмчин цагаан хөхийн сүүг хөхүүлж сэхээгээд, эх хөвгүүн хоёулан дөрвөн мөрний мах барагдтал сэлэн сэлэн үүрч хийдэд хүргэж орхисонд гурван цагийн бурхан багш би Дарь эхийн чинь сүүний ачийг хариулсуу гэж навч хар морь болоод унуулж явсан минь тэр билээ. Эдүгээ зургаан зүйлийн эх болсон Цагаан Дарь эхийн санасан хэрэг номын ёсоор бүтэх болтугай.

Амгалан жаргалангийн өлзий тогтох болтугай” хэмээн ерөөл тавиад гурван цагийн бурхан багш гурван мянган шавь нараа дагуулж ариун тариаланд өөд одов. Цагаан Дарь эхийн хойноос ерөөл тавивай. “Энэ явах үйлд чинь буяны нөхөр сэлт болон навч хар морь болж аваачиг, хойт төрөлдөө шажин ном хоёрын үндэснээс хагацал үгүй төрөх болтугай.

Гайхамшигийн дээд гарсан гартаа луугийн таяг барьсан шагжаан гэлэн болж төрөх болтугай” хэмээн ерөөл тавиад тэр цагийн орны амьтан бүгдээр энх жаргалан, мөнх насаар амгалангийн ёсоор жарган суусан буй. Зуны дунд сарын арван есний шөнөд Зандан төгссөн эх дагинын хувилгаан нэгэн зүүд барив.

Алтан орд харшийн орой булгаран аялгуу мандарваа цэцэг булагдав. Тэр юун буй. Сүмбэр уул мэт хатан эжий минь амар мэнд байхуйнай, үтэр од! гэж зарлиг болсонд Аюу бодьсад хатан эжийнхээ орд харшид очиж үзнэ гэхүүнэ алтан ширээ тэврэн

хэвтсэнд амьсгалыг гадагш дотогш хоёул үгүй, амь гол нь бөглөрөн, үг чичрэн, сэтгэл долгисон алтан ширээг тэврэн мөн тэнд үхэдхийж унав.

Нэг цагийн үе болон гасланд дарагдан босоод сүмбэр уул мэт унд болсон эжий минь Сухавадийн оронд төрөх болтугай хэмээн ерөөл тавиад, Аюу бодьсад минь юуны шалтгаан болов хэмээн ламын ламд айлтгаадуй хэдүй сүмбэр уулын оргил бүр биеэрээ хайгаад юм эс олов.

Арслан уулын орой дээр гарч явтал нэг гурван толгойтой богширго анги болон харьсанд Зандан эх зарлиг болон асуув.

“Эгшиг жигүүртэн минь нүдэндээ юун үзэв, чихэндээ юун сонсов” гэж асуув. Тэр богширго “Нүдэндээ юм эс үзэв, чихэндээ юм эссонсов, би” гэхүйд нэг толгой нь хэлэв.

“Энэ арслан уулын хонгилд Цагаан Дарь эхийн хувилгаан оршив гэхүйг сонсов би” гэв. Зандан дагина зарлиг болов.




“Энэ насандаа жигүүртэн болж төрөвч, хойт төрөлдөө алтан ширээний гэлэн болж төрөх болтугай” гэж ерөөл тавиад явав. Арслан уулын оргил дээр гаран гүйхнээ хүжийн үнэр анхилан гарвай.

Тэр цагт үзэн зургаан зүйлийн эх өөд болон суухыг Зандан дагина үзээд алтан ширээг тэврэн унав.

Тэр эх зарлиг болов. “Зандан төгссөн эх дагинын хувилгаан минь! Гаслах дуугаан хураан үйлд! Уйлан эмгэнэхүй учир үгүй!” хэмээн зарлиг болсонд Зандан дагина талбин суув.

Эх хөвгүүн нийт бүрэн нийлэлдэж хүслээ ханалцваа. Тэр гурван цагийн өлзий оршуулан бүгдийг жаргуулан суусанд Дарь эхийн нэгэн бүлэг тууж төгсөв.

“Цагаан дара эхийн тууж хэмээх оршив”



1  
 2  
 3  
 4  
 5  
 6  
 7  
 8  
 9  
 10  
 11  
 12  
 13  
 14  
 15  
 16  
 17  
 18  
 19  
 20  
 21  
 22  
 23  
 24  
 25  
 26  
 27  
 28  
 29  
 30  
 31  
 32  
 33  
 34  
 35  
 36  
 37  
 38  
 39  
 40  
 41  
 42  
 43  
 44  
 45  
 46  
 47  
 48  
 49  
 50  
 51  
 52  
 53  
 54  
 55  
 56  
 57  
 58  
 59  
 60  
 61  
 62  
 63  
 64  
 65  
 66  
 67  
 68  
 69  
 70  
 71  
 72  
 73  
 74  
 75  
 76  
 77  
 78  
 79  
 80  
 81  
 82  
 83  
 84  
 85  
 86  
 87  
 88  
 89  
 90  
 91  
 92  
 93  
 94  
 95  
 96  
 97  
 98  
 99  
 100

1  
 2  
 3  
 4  
 5  
 6  
 7  
 8  
 9  
 10  
 11  
 12  
 13  
 14  
 15  
 16  
 17  
 18  
 19  
 20  
 21  
 22  
 23  
 24  
 25  
 26  
 27  
 28  
 29  
 30  
 31  
 32  
 33  
 34  
 35  
 36  
 37  
 38  
 39  
 40  
 41  
 42  
 43  
 44  
 45  
 46  
 47  
 48  
 49  
 50  
 51  
 52  
 53  
 54  
 55  
 56  
 57  
 58  
 59  
 60  
 61  
 62  
 63  
 64  
 65  
 66  
 67  
 68  
 69  
 70  
 71  
 72  
 73  
 74  
 75  
 76  
 77  
 78  
 79  
 80  
 81  
 82  
 83  
 84  
 85  
 86  
 87  
 88  
 89  
 90  
 91  
 92  
 93  
 94  
 95  
 96  
 97  
 98  
 99  
 100

1  
 2  
 3  
 4  
 5  
 6  
 7  
 8  
 9  
 10  
 11  
 12  
 13  
 14  
 15  
 16  
 17  
 18  
 19  
 20  
 21  
 22  
 23  
 24  
 25  
 26  
 27  
 28  
 29  
 30  
 31  
 32  
 33  
 34  
 35  
 36  
 37  
 38  
 39  
 40  
 41  
 42  
 43  
 44  
 45  
 46  
 47  
 48  
 49  
 50  
 51  
 52  
 53  
 54  
 55  
 56  
 57  
 58  
 59  
 60  
 61  
 62  
 63  
 64  
 65  
 66  
 67  
 68  
 69  
 70  
 71  
 72  
 73  
 74  
 75  
 76  
 77  
 78  
 79  
 80  
 81  
 82  
 83  
 84  
 85  
 86  
 87  
 88  
 89  
 90  
 91  
 92  
 93  
 94  
 95  
 96  
 97  
 98  
 99  
 100

1  
 2  
 3  
 4  
 5  
 6  
 7  
 8  
 9  
 10  
 11  
 12  
 13  
 14  
 15  
 16  
 17  
 18  
 19  
 20  
 21  
 22  
 23  
 24  
 25  
 26  
 27  
 28  
 29  
 30  
 31  
 32  
 33  
 34  
 35  
 36  
 37  
 38  
 39  
 40  
 41  
 42  
 43  
 44  
 45  
 46  
 47  
 48  
 49  
 50  
 51  
 52  
 53  
 54  
 55  
 56  
 57  
 58  
 59  
 60  
 61  
 62  
 63  
 64  
 65  
 66  
 67  
 68  
 69  
 70  
 71  
 72  
 73  
 74  
 75  
 76  
 77  
 78  
 79  
 80  
 81  
 82  
 83  
 84  
 85  
 86  
 87  
 88  
 89  
 90  
 91  
 92  
 93  
 94  
 95  
 96  
 97  
 98  
 99  
 100







100  
 101  
 102  
 103  
 104  
 105  
 106  
 107  
 108  
 109  
 110  
 111  
 112  
 113  
 114  
 115  
 116  
 117  
 118  
 119  
 120  
 121  
 122  
 123  
 124  
 125  
 126  
 127  
 128  
 129  
 130  
 131  
 132  
 133  
 134  
 135  
 136  
 137  
 138  
 139  
 140  
 141  
 142  
 143  
 144  
 145  
 146  
 147  
 148  
 149  
 150  
 151  
 152  
 153  
 154  
 155  
 156  
 157  
 158  
 159  
 160  
 161  
 162  
 163  
 164  
 165  
 166  
 167  
 168  
 169  
 170  
 171  
 172  
 173  
 174  
 175  
 176  
 177  
 178  
 179  
 180  
 181  
 182  
 183  
 184  
 185  
 186  
 187  
 188  
 189  
 190  
 191  
 192  
 193  
 194  
 195  
 196  
 197  
 198  
 199  
 200

201  
 202  
 203  
 204  
 205  
 206  
 207  
 208  
 209  
 210  
 211  
 212  
 213  
 214  
 215  
 216  
 217  
 218  
 219  
 220  
 221  
 222  
 223  
 224  
 225  
 226  
 227  
 228  
 229  
 230  
 231  
 232  
 233  
 234  
 235  
 236  
 237  
 238  
 239  
 240  
 241  
 242  
 243  
 244  
 245  
 246  
 247  
 248  
 249  
 250  
 251  
 252  
 253  
 254  
 255  
 256  
 257  
 258  
 259  
 260  
 261  
 262  
 263  
 264  
 265  
 266  
 267  
 268  
 269  
 270  
 271  
 272  
 273  
 274  
 275  
 276  
 277  
 278  
 279  
 280  
 281  
 282  
 283  
 284  
 285  
 286  
 287  
 288  
 289  
 290  
 291  
 292  
 293  
 294  
 295  
 296  
 297  
 298  
 299  
 300

301  
 302  
 303  
 304  
 305  
 306  
 307  
 308  
 309  
 310  
 311  
 312  
 313  
 314  
 315  
 316  
 317  
 318  
 319  
 320  
 321  
 322  
 323  
 324  
 325  
 326  
 327  
 328  
 329  
 330  
 331  
 332  
 333  
 334  
 335  
 336  
 337  
 338  
 339  
 340  
 341  
 342  
 343  
 344  
 345  
 346  
 347  
 348  
 349  
 350  
 351  
 352  
 353  
 354  
 355  
 356  
 357  
 358  
 359  
 360  
 361  
 362  
 363  
 364  
 365  
 366  
 367  
 368  
 369  
 370  
 371  
 372  
 373  
 374  
 375  
 376  
 377  
 378  
 379  
 380  
 381  
 382  
 383  
 384  
 385  
 386  
 387  
 388  
 389  
 390  
 391  
 392  
 393  
 394  
 395  
 396  
 397  
 398  
 399  
 400

401  
 402  
 403  
 404  
 405  
 406  
 407  
 408  
 409  
 410  
 411  
 412  
 413  
 414  
 415  
 416  
 417  
 418  
 419  
 420  
 421  
 422  
 423  
 424  
 425  
 426  
 427  
 428  
 429  
 430  
 431  
 432  
 433  
 434  
 435  
 436  
 437  
 438  
 439  
 440  
 441  
 442  
 443  
 444  
 445  
 446  
 447  
 448  
 449  
 450  
 451  
 452  
 453  
 454  
 455  
 456  
 457  
 458  
 459  
 460  
 461  
 462  
 463  
 464  
 465  
 466  
 467  
 468  
 469  
 470  
 471  
 472  
 473  
 474  
 475  
 476  
 477  
 478  
 479  
 480  
 481  
 482  
 483  
 484  
 485  
 486  
 487  
 488  
 489  
 490  
 491  
 492  
 493  
 494  
 495  
 496  
 497  
 498  
 499  
 500





Handwritten Mongolian script on a rectangular strip of aged paper, featuring approximately 15 lines of text.

Handwritten Mongolian script on a rectangular strip of aged paper, featuring approximately 15 lines of text.

Handwritten Mongolian script on a rectangular strip of aged paper, featuring approximately 15 lines of text.

Handwritten text in Mongolian script on a rectangular piece of aged paper. The text is written in a cursive style and occupies most of the page.

Handwritten text in Mongolian script on a rectangular piece of aged paper. The text is written in a cursive style and occupies the left side of the page, with several horizontal lines remaining blank on the right side.







**ЭРДЭНЭ ЗАЯ БАНДИДА  
ЛУВСАНДАНЗАНПУЛЖИНЖИГМЭД  
ГЭГЭЭНТЭН**

## **ХАЛХЫН ЭРДЭНЭ ЗАЯ БАНДИДА ЛУВСАНДАНЗАНПҮЛЖИНЖИГМЭДИЙН НАМТАР**

1972 оны 1 сарын 18-нд Архангай аймгийн Цэцэрлэг хотын төвд аав Самбуу, ээж Цэрэнлхам нарын отгон хүү болон мэндэлжээ. Хувилгааныг тодруулахаар 1989 онд Далай багшид айлтгал өргөж Архангай аймагт төрсөн 1600 хүүхдээс шалган, 1999 онд Зая гэгээний XV хувилгаан мөн хэмээн эндүүрэлгүй тодруулжээ.

Хувилгаан тодорсон цагаасаа номонд хичээж нутгийн гавж Ц.Отгонбаяраар түвд үсэг заалган, нутгийн сүсэгтэн олны хүсэлтээр Архангай аймагт Ламын цогчид өргөж, уул усны тайлга, тахилга үйлдэж өөрийн хийдийн гол шүтээний нэг болох Балданлхам бурханыг хос мөнгөн бишгүүрийн хамт хойморт нь залж, хоёр арслан бүтээн үүдийг нь мануулжээ. Засаг дарга нар хүлээн авч, лам нар бүрээ бишгүүр үлээн Сэнбэрэмтэй угтаж, ширээнд нь залж мандал өргөв. Энэтхэгийн газар бүрээс, Гомон, Сэра, Лосолин, Гандан гэх мэт олон газраас заллага айлтгасны учир Далай багшид бараалхахаар Энэтхэг газарт морилжээ.

Дээрхийн гэгээнтэн Далай ламтан бээр миний тодруулсан Зая гэгээнтэн мөн хэмээн дахин баталж, хувилгааны тамгыг гардуулж 700 гаруй хувилгаадынхаа дээрээс нь гуравт залж, дэлхийн бурхан шашны 3 том сургуулийн нэг болох Сэра жэ дацанд шавилахыг санал болгон тусгайлан байр бэлтгүүлж шавилан суун эрдэм номоо суралцаж байгаад номын чөлөөгөөр сүсэгтэн олны хүсэлтээр төрсөн нутагтаа морилоход засаг төрийн түшээд болон шашны тэргүүнүүд угтан Монголын Бурхан Шашны Төв Гандантэгчилэн хийдэд сэнбэрэмтэй залж, мандал өргөсөн.

Бас Зүүн Хүрээ Хийдийн Дамбажав ламтан хийддээ залж мандал өргөв. Засаг төрийн 3 өндөрлөгт удаа дараа бараалхаж, Монгол улсынхаа ургац арвин, унац ихтэй, зуд турхангүй байлгахын тухайд тусгай төсөл боловсруулан танилцуулж Далай ламын хийдүүдэд жилийн жасаа даатгалын хурлыг тогтмол хуруулж буй билээ.

Лам нарынхаа боловсролыг дээшлүүлэхийн тулд Гандантэгчилэн хийдэд хөдөөнөөс олон лам нар авчиран ном заалгаж улмаар тэндээс Энэтхэгт олноор нь суралцуулж байгаа

болно.

2006 онд Монгол нутагтаа буцан ирж Улаанбаатар хотноо Гүшиг дацанг байгуулан өөрийн шавь нарын хамт хурал номоо хурах болсон бөгөөд түүний хажуугаар Архангай аймаг тэргүүтэн бусад хөдөө орон нутаг руу чиглэсэн бурхан шашны олон үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Галданзуу хийдийг сэргээн засварлаж, Арын Хангайчуудын их шүтээн Зуу бурханыг бүтээн залсан.

2010 онд Монгол орныг гал, ус, газар, салхины хорлолоос хамгаалахын тухайд 4 суврагыг баруун, зүүн, хойд, хил дээр бүтээлгэж, ган гачигыг арилгах, хур бороо оруулахын тухайд их нуурууд, гол усанд дүлцэнгийн элс өргүүлэх тэргүүтэн номын үйл ажиллагаа цаглашгүй ихийг үйлдэн шавь нар хийгээд монгол орныхоо төр шашин, хүн ард тэргүүтэй сав шим ертөнцийг таалалдаа багтаан их нигүүлсэнгүйгээр болгоосоор байна.

## **Зая гэгээн Лувсанданзанпүлжинжигмэдийн төрөл тутмын залбирал**

Хутагтын оронд бурхан заларч  
Хувьтай түмэнд увидас хайрлахад  
Эрдэнийн элс өргөн барьж бодь сэтгэл үүтгэсэн  
Эзэн хаан Жансэмжамбад залбирнам

Бурхан багшийн номын рашаанаар  
Бүх дэлхий нийтээр чийглэгдэхэд  
Гаслант хүмүүсийг зовлонгоос тэтгэгч  
Гайхамшигт хаан Ашокад залбирнам

Эрдэнэ гуравт хувиралтгүй сүсэглэж  
Энгийн нүдэн дор энэрэхүйн хүү шиг тэтгэн  
Чөлөө учрал бүрдсэн оронд мэндэлсэн  
Чимэг үзэсгэлэнт Товусамбууд залбирнам

Хутагтын орны дээдсийн хөрөнгөөс  
Хувиар хүмүүст өглөг тэргүүтнийг гүйцээж  
Үгээгүй түмний тусад үр эд хайрлагч  
Үнэн ачит Шубумгарад залбирнам

Цаст түвдийн баруун хойд зүгийн  
Цагийн муугийн Лэдак шавь нарыг  
Хилэнт дүрээр номхотгон зассан  
Хосгүй ловон Раднасэдэд дор залбирнам

Энэтхэг орны өндөр язгуурт мэндэлж  
Энэлсэн түмэнг гангийн рашаанаар сэрүүцүүлж  
Дээдсийн мөрийг нээгч тэрэг орчлонгийн нүдэн  
Дияанч Лодойдамбын өлмийд залбирнам

Байдал нь Шагшаа бодь лугаа төгөлдөр  
Бясалгал ухаан нь үнэрт зандан мод адил  
Дэлбээлэх цэцгийн үнэр нь анхилам  
Дээдэс Содномбалтүв дор залбирнам

Цог төгөлдөр охин тэнгэрийн адистэдээр  
Чуулган үйлсийн их далайг  
Цэцнээр гатлах онгоцыг жолоодогч  
Чандмань эрдэнэ Вүдан гэгээнд залбирнам

Цаст түвдэд залрах замыг анхан нээж  
Цуут Ванчин Богд Ашока хэмээн лүндэгнэж  
Амьтны тусыг хийж мөнгөн суврага бүтээсэн  
Ар Халхын Хөндүлэн Цохур ноёнд залбирнам

Хоёр дээдэс Ванчин Далай ламын  
Хувь төгөлдөр шавиар илт үнэлэгдэж  
Ариун номын хурыг нутагтаа буулгагч  
Алдарт Зая Лувсанпринлэйд залбирнам

Урьдын дээдсийн мөрөөр түвдэд заларч  
Урсах гангын рашааныг нутагтаа салаалан  
Агь тарнийн номыг эцэслэн агуйг сахигч  
Аглаг даяанч Лувсаннамжилд залбирнам

Хол тасран түрүүлэх ажнай хүлэг шиг  
Хосгүй ядам сахиустай гүн нөхөрлөж  
Судар тарнийн эндүүрэлгүй эцэслэсэн  
Суут Лувсанжигмэд доржид залбирнам

Зая бандидын алдар шашны хэнгэрэгийг  
Замхарал үгүй арвидуулж зохиох үүрэгт  
Амьтныг тэтгэгч билэг төгөлдөр багш  
Ачит Лувсанняндаг дор залбирнам

Хувилгаан журамт лагшинг эрхшээн  
Хөг яруу зарлигаар олонд алдаршсан  
Шоронд залравч энэрэхүйн таалалтай  
Шамдалт дээдэс Жамбацэрэнд залбирнам

Ардчиллын ногоо монголд үрслэж  
Ардууд сүсгээр хойт дүрийг хайхад  
Далай багшаас Архангайд энэ хэмээсэн  
Данзанпүлжин Жигмэд дор залбирнам

Учир шалтгаан бүрдсэн монголд  
Уг санааг ерөөлчилөн бүтээсэнд  
Зая бандидын дүр бүхэнд залбирнам бид  
Заяат дээдийн номыг дэлгэрүүлж адисла.

Энэхүү төрөл тутмын залбирлыг Хандсүрэн, Бавуудорж нар Зая гэгээнтний уншлага хэрэгтэй байна хэмээсний дагуу Гандан хийдийн лам нарын адаг Гавж нэрийг зүүгч Ц.Отгонбаяр бээр Ванчин Богдын зохиосон Зая Лувсанжигмэд гэгээний төрөл тутмын залбирлаас ишлэн Илжиг хэмээх Туулай жилийн өвлийн адагсарын шинийн 7-нд үйлдэвэй. Үсгийг бичиж шивсэн номын санч Г.Жалсрайжамц.

## ХОРИН НЭГЭН ДАРЬ ЭХ ТУС БҮРИЙН АЛДАР ХИЙГЭЭД ТАРНИЙН ЯЛГАМЖАА ТЭДГЭЭРИЙН ДАГАН СОЁРХОЛ

Ерөнхий гэтэлгэгч Дарь эхийн тарни бол **Ум дари дүдари дүри сууха** мөн боловч ялгавартай хорин нэгэн Дарь эх тус бүрдээ өөр байдаг тэдгээрийг хэрхэн унших хийгээд тус эрдмийг нь товчхон өгүүлбэл.

1. Анхдугаар дарь эх Хутагт түргэн туслагч баатар охин бөгөөд түүний тааллын мутрын бумбанаас тарнийн эрхис улаан гэрлээр цацарч, хязгаарлашгүй юу бүхний харшлах тотгор нугуудыг төмөр гохоор цаламдан авчирч миний өлмийн өмнө толгойгоо бөхийлгөсөн байдалтай оршин дахин улаан гэрэл цацарч бүтээх энэ бүхний эхлэл хилэнц түйтгэр арилж миний сэтгэлд зохистой болон хувирч байна гэж санаад **Ум дари дүдари дүри сарва дэрм дадур вашуун гүрү сууха** олон удаа уншиж айлтгана.
2. Хутагт охин амирлангуй түүний таалалын мутрын бумбанаас тарнийн хэлхээ цагаан гэрэл хэмжээлшгүй цацарч өөрийн болон хүмүүний оройноос угаан соёрхож өвчин хилэнц түйтгэр ад зэтгэр, шахагдан хөөгдөж өөр хийгээд бүтээхүй хүмүүний бие болор мэт тунгалаг гэж санаад **Ум дари дүдари дүри сарва бавун шиндан гүрү сууха** хэмээн олон удаа уншсанаар амирлангуй үйл бүтэх болно.
3. Хутагт охин алтан өнгөт түүний таалалын мутрын бумбанаас тарнийн эрхис алтан өнгөт гэрэл хязгаарлашгүй гарч өөр хийгээд бүтээгчийн бие орон тэргүүтэнд дуслан гэрэл нь нийлж хутагт охин гал өнгөт рашаанаар дүүрсэн бумба бий болж өөр болон бусдын оройноос абшиг өгч биеийн гаднаас дотор зүгт алт түгээж байгаа мэт нас эдлэл аригдаж байна гэж санаад **Ум дари дүдари сарваан аюу буна бушдам гүрү сууха** хэмээн олон тоолоод дэлгэрүүлэхийн үйл бүтнэ.
4. Тийн ялагч охин түүний мутрын бумбанаас тарнийн эрхис улаан шаргал гэрэл гох мэс цацарч орчлонгийн сав шим ялангуяа үхэлгүй насны язгуурыг олон эрхшээсэн улаан шаргал рашааны байдалтай гохдон ирж ялж төгс нөгчсөн

бурханы хэсэг бүрээс мутрын бумбанд шингэж бууж биеийн дотор бүгдийг дүүргэн цаг хийгээд цаг бусын үхлийг айлган үхэл үгүйн шид бүтээлийг оллоо хэмээн санаад **Ум дари дүдари дүри аюурзана хэрэ бам сууха** хэмээн олон удаа уншваас нас зуу хүртэл арвижих болой.

5. Хутагт охин хумын дууг дурсгагч түүний тааллын мутрын бумбаас тарнийн эрхис гох цалам мэт оосорлож хязгааргүй гэрэл цацран дайсны хоолойгоор хүлж чирч гулдчин өөрийн эрхгүй болгон толгойгоо бөхийлгөж байсан байдалтай байна гэж бодоод **Ум дари дүдари дүри амуго агар хаяа хэрэ сууха** хэмээн олон удаа уншиж үйлд.
6. Хутагт охин гурван орчлонг ялагч охин түүний тааллын мутрын бумбанаас тарнийн эрхис галын оч хэмжээлшгүй гэж арван зүгт цацарч үнэр идэшт, арван зүгийг тэтгэгч нугуудад тусаж тэдгээрийн хорлох хорлол уур зэтгэр хилэнц шатаагдан ариусаж миний боол мэт болж байна гэж санаад **Ум дари дүдари сарваа бигнаа шадармаа үзадари сууха** хэмээн олон удаа уншиж үйлд.
7. Хутагт бусдын хүчээр дарагч охин түүний мутрын бумбанаас тарнийн эрхис хүчтэй хатуу арван зүгт цацарч гадны тэрсүүдийг даран сөнөөж дахин гэрлийн чуулган цацарч бүтээлгэх бие ямагт гэрлийн хүрээ завсаргүйгээр тойрсон хэмээн бодож **Ум дари дүдари сарваа бидяа аварана еэ би пад сууха** хэмээн олон удаа үйлдвээс муу тарничин бүхнийг дарах болно.
8. Хутагт тэрсүүд дайсныг дарагч охин түүний тааллын мутрын бумбанаас тарнийн эрхис ирт мэс хэмжээлшгүй цацраад дайсны зорилгыг зүрхний үндсэн тольтдоо амины мөн чанараар гал мэт хараад түргэн амины мөн чанараар гал мэт хараад түргэн шатааж мах цус яс ч үл үлдээхэд санаж **Ум дари дүдари дүүри сарваа шадармаа арияа пад сууха** хэмээн олон удаа уншиж дайсны амийг таслах болой.
9. Хутагт охин чухал дэгээн тэмдэгч байдалтай түүний тааллын мутрын бумбанаас тарнийн эрхис цагаан өнгийн гэрэл цацарч



энэ насны тэргүүтэнээс би ямагт хамгаалагдаж байна хэмээн санаад дахин тарнийн эрхист цагаан рашаан бууж угаал өргөж хилэн царилж байна хэмээн санаад **Ум дарэ дүдари дүри мама сарваа бадавин би рагчаа рагчаа** хэмээн олон уншваас гаднаас хамгаалах болой.

10. Хутагт орчлонг эрхэндээ хураагч охин түүний таалалын мутрын бумбанаа старнийн эрхис манан мэт түгж тэрсүүд нарын хилэнцийг хамтад нь арилгаж би ямагт баясахуй хэмээгээд бишрэхүйн үүднээс эрхэндээ оруулж байна хэмээн санаад **Ум дарэ дүри дүдари сарваа маха лхогоо багшим гүрү суухаа** хэмээн уншиж үйлдвээс үйл бүгдийг эрхэндээ оруулж үйлдэнэ.
11. Хутагт хоосныг арилгагч охин түүний таалалын мутрын бумбанаас тарнийн эрхис улаан гох мэт арван зүгт цацарч ертөнцийн хүн төрөлхтөнд эд эдлэх сан эрдэнийн хөмрөг тэргүүтэн товчилвоос хотол чуулган өөрийн эрхгүй аяндаа хурах болно. Өөрийн гэх орон эд эдлэлээр дүүрч хоосрохын зовлонгоос хагацаж байна хэмээн санаад **Ум дарэ дүдари дүри басу дарча сууха** хэмээн олон удаа уншваас эд аривах болно.
12. Хутагт өлзий оршигч охин түүний таалалын мутрын бумбанаас тарнийн эрхис алтан өнгөт гэрэл цацарч орчлон ертөнцийг өлзийгөөр дүүргэж өөрт шингэж өлзий сайн амгалан түгж байна гэж санаад **Ум дарэ дүдари мангала сида сууха** хэмээн олон удаа уншваас өлзий түгэх болно.
13. Хутагт гол мэт бадарч охин түүний тааллын мутрын бумбанаас тарнийн эрхисийн очирын мөн чанарт хязгаарлашгүй түгж би хийгээд бүтээх үйл тэргүүтэн очирын хүрээ гэр бий боллоо хэмээн санаад **Ум дарэ дүдари дүри бодояа байшим гүрү суухаа** хэмээн олон удаа уншваас барцадаас сахих болой.
14. Хутагт уур хилэнт охин түүний тааллын мутрын бумбанаас тарнийн эрхисийн хүчтэй хатуу галан бөмбөлөг мэс байдалтай хэмжээлшгүй цацарч дайсан бүгдийг дарж байна хэмээн санаад **Ум дарэ дүдари дүри базар маха бодоез башим**

**гүрү сууха** хэмээн олон удаа уншиж бүгдийг дарах болой.

15. Хутагт их амирлангуй охин түүний тааллын мутрын бумбанаас тарнийн эрхис цагаан бумбын рашаан мэт хэмжээлшгүйцацарч би ямагт тарнийг тоолж үйлдвээс угаал өргөж хилэнц бүгд арилж болор шил мэт тунгалаг боллоо хэмээн бодоод **Ум дарэ дүдари сарва бам бараа мани еэ суухаа** хэмээн олон удаа уншаад хилэнц арилгах аргын дээд болой.
16. Хутагт охин хум үсгээр гэтэлгэгч охин түүний тааллын мутрын бумбанаас тарнийн эрхис нарны гэрэл мэт өнгөт цацар чарвис тарничинг илт татан авчирч өөртөө шингээн номын билэгчийн чуулган дэлгэрлээ хэмээн санаад **Ум дари дүдари дүри сарва дарма барамза бари шодони суухаа** хэмээн олон удаа уншваас ухааныг аривжуулах болой.
17. Хутагт гурван орчлонг хөдөлгөгч охин түүний тааллын мутрын бумбанаас тарнийн эрхис төмөр бөмбөлөг цалам гадас очир тэргүүтнээ байдалтай цацарч дайсан хулгайчийг даран сөнөөж газрын есөн үе доош болж очирын дуугаар дарсан гэж **санаад Умдари дүдари дүри сарва зоро дамбани суухаа** хэмээн олон удаа уншиж хулгайчийг дарах болой.
18. Хутагт хорыг арилган үйлдэгч охин түүний тааллын мутрын бумбанаас тарнийн эрхисээс цагаан гаврын үргэлжлэл мэт мөн чанартаа биеийн дор шингэж лус савдгийг зайлуулж бие ариусах хэмээн санаад **Ум дари дүдари дүри сарва наго бишма шандан гүри суухаа** хэмээн олон удаа уншиж лус савдгийн хорлолд үл өртөнө.
19. Хутагт зовлонг арилгагч охин түүний тааллын мутрын бумбанаас тарнийн эрхис цагаан зочин мэт нааш цааш үсчин муу зүүд ёрын язгуур бүхийг амирлуулж үйлдэн хэрүүл тэмцэл хийгч нугууд асралгүй сэтгэлийг бариад буяны билиг хотол чуулган болж байна гэж санаад **Ум дари дүдари дүри сарваа дүр совони мозожани сууха** хэмээн олон удаа уншиж муу зүүд арилах болой.
20. Өвчнөөс хамгаалан арилгагч охин буюу түүний таалалын

мутрын бумбнаас тарнийн эрхисэн хутагт охин амирлангуй хэмжээлшгүй залраад амирлангуй нугууд бээр лагшингаар цувиралтгүй билиг билгийн рашаан бууж өвчин нугуудыг илааршуулж амирлуулан үйл үйлдэж номхруулж байна хэмээн санаад **Ум дари дүдари дүри сарваа бидеэ зара баршаа маниеэ** суха хэмээн олон удаа уншаад өвчин амирлах болой.

21. Үйлсийн хутагт үйлсийг цогцлоогч охин түүний таалалын мутрын бумбанаас тарнийн эрхис дөрвөн үйлийн дэс дараагаар зохилдох гэрэл цацраад үйл бүгд бүтэж байна хэмээн санаад **Ум дари дүдари дүри сарваа сиди сууха** хэмээн олон удаа уншиж үйл бүгдийг бүтээх болой.



*Архангай аймгийн Спорт  
цогцолборт Зая гэгээнтний айлдсан  
Цагаан дарь Эхийн авшигийн үеэр*

**ЭРДЭНЭ ЗАЯ БАНДИДА ГЭГЭЭНТЭН  
ЛУВСАНДАНЗАНПҮЛЖИНЖИГМЭДИЙН  
МОНГОЛ ХЭЛЭЭР АЙЛДСАН ЦАГААН ДАРЬ  
ЭХИЙН АВШИГ**

Та бүхний энэ өглөөний амгаланг айлтгая бурхан багш бээр / Шагт шигүүн бар Чоймасан / 49 хоног ном номлоогүй байдаг. Энэ үед өөрийн шавь нар бурхан яагаад амьтаны тус хийж ном номлодоггүй вэ? Хэмээн асуухад Бурхан багш бээр надад ном номлоод өгөөч гэсэн өглөгийн эзэн олдоогүй гэж хариулсан гэдэг.

Энэ нь цаанаа хоёр учиртай 1-рт Зовлонгийн үнэний тухай ном номлох гэж байсан учраас гатав бясалгал хийж ном номлоогүй гэдэг. 2-рт Ном гүллэх өглөгийн эзнийг эрхэм чухлыг харуулахын тухайд ингэж айлдсан гэдэг хоер янзын тайлбар байдаг.

Намайг Цагаан дарьхийн Цэваан буюу насны авшигийг айлдаж өгөөч хэмээн өглөгийн эзэн Самдангийн Нямдаваа түүний эх Хандсүрэн нар Архангайн Баян уул багийн иргэн миний урд болон энэ насны шавь Гунгаа овогтой Цэрэнбатаа ламтан олон удаа хүссэн боловч амжихгүй байсаар ертөнцийн мөнх бусыг үзсэн учраас түүний хүүхэд үр ач нар уламжлан хүсэлт илэрхийлсний эцэст энэхүү дарь эхийн цэвааныг тавих болсон шалтаг шалтгаан болно.

Өөрийн зүгээс шалтгаалах нөхцөл бүрдсэн гэж би ойлгож байгаа. Миний уг гарал төрөл хувилгааны анхны дүр 2500 аад жилийн өмнө бурханы гэгээний ном номлож байх үед учиран бараалхаж алтан элс өгч бодь сэтгэлийг үүсгэсэн Жамсимжамба буюу Майдарын гэгээний хувилгаан бодьсадва байдаг ба түүний удаа номыг тэтгэгч Ашока хаанаар мэндэлж дараалан Товосамбуу Шубумгара гэх мэт номын мэргэд болон Энэтхэг хутагтын оронд мэндэлж байжээ.

Түүний дараа хойд Энэтхэг болон ладакт ловон Раднасэд мөн даянч Лодойдамба нарын дүрээр өндөр язгуурт номын мэргэд болон одоогийн Түвд, Энэтхэгийн завсар нутгаар мэндэлж байгаад Цаст түвдийн оронд Содномбалтав, Будан гэгээнтний дүрээрзалагдаж шашин амьтны тусыг хийж байв.

Энэхүү намтарыг баталгаажуулж Ванчинбогд бээр халх 4 хошуунд хааны дайтай өргөмжлөгдөж явсан хөндлөн цокур ноёныг

Түвдөд бараалхаж 4 дүгээр далай лам Ёндонжамцын гүдэн суваргыг мөнгөлж бурханы шашныг дэмжин зохиосныг эхээр хөхүүлэн дэмжиж Ашоко хааны удмын хүн гэдгийг зарлан тунхгалж хаш тамга соёрхон төрөл удмын залбиралыг зохион өөрт нь барьсан байдаг.

Түүний дараа Зая лувсанпэрэнлэй гэгээн 1642 оны зуны эхэн сага сарын шиний арван тавны үүрээр аав Сунтар ээж Орхойдой нараас лагшин мэндэлж элдэв сонин гайхамшигийг үзэн бага насаа өнгөрүүлж 1647 оны бүхнийг номохтгогч хэмээх гал эм нохой жил Лодойжамц ламаас гэлэнгийн сахил хүртэж лам болох анхны сууриа тавьсан.

1652 он буюу баясгалан хэмээх усан эр луу жил Ловон унзад Шарав рэнчингээр харанг магтаал сахиус Сандэчигсүм зэрэг номыг заалгаж цээжлэн сайшаагдаж 1653 он тийн ялагч хэмээх усан эм могой жил Жамъянцоржи хувилгаанд бараалхаж ноён хутагт хэмээн цол өргөмжлүүлэн.

1657 оны сэржан хэмээх гал эм тахиа жилийн зун Эрдэнэ зууд морилж дөрвөн хошууны цуглаанаар өндөр гэгээнд бараалхихдаа Чойрын гэвш нарын ном хаялцахыг сонсож сэтгэл уяран түвд явж ном сурахаар хатуу шийдсэн.

1659 онд өндөр гэгээнд түвд хэл дээр солигдов зохиож Доржнамжимын жавтүйг монгол хэлэнд орчуулсныг номын хаан таалан сайшаав.

1662 оны буян үйлдэх хэмээх усан бар жил Монголын 1-рсарын 29 Гүйдэр сахиус хурах үед Ванчин богдод анхлан бараалхаж гэцэлийн сахил хүртэж хөндлөн цоокур ноёны хойд дүр удамт Махабанида зая Лувсанпэрэнлэй мөн хэмээн тодруулсан.

Үүнээс эхлэн Монголд Зая Лувсанпэрэнлэй, Зая Лувсанннандаг, Зая Лувсанжигмэддорж, Зая Лувсанжигмэднамжил, Зая Лувсанчойжийнямаа буюу Жамбацэрэн гэгээтэн түүний дараагаар миний бие зая Лувсанданзанпүлжинжигмэд хэмээн 14 дүгээр Далайлам Данзанжамц бээр тодруулсан байдаг.

Иймээс төрөл удмын хувьд миний урд дүрүүд ихэнхи нь дарь эхийн цэваан айлдаж байжээ. 1668 он-элдэв хэмээх модон эм могой жил Лхас Потола ордонд эхэсийн дэргэд сожин айлдаж номын эзэний хүсэлтээр дархийн цэваныг монгол хэл дээр айлдаж байжээ. Иймээс би цэван айлдах боломжтой юмуу хэмээн бодож сууна.

Мөн дээрхийн гэгээнтэн 14 дүгээр далай ламаас 3 удаа, намжираа хамба Жадо рэнбүүчигээс 2 удаа, сэра хамбаас 1 удаа, Дармаалочин лхаарамбаас 1 удаа дарь эхийн цэваны авшигийг хүртэж нянба хийж дархийн тогтоол тарнийг бум хүргэсэн билээ. Ингээд цэваан айлдах бэлтгэл болон бодит төгсгөлийн гэх үндсэн сэдэв рүүгээ оръё.

Хутагт охин Тэгүүнчилэн ирэгсэн

Цагаан дарь эх буюу Ичинхорлоогийн

үүднээс насны авшиг айлдах ёс, дээд багш нарын

увидас үхэлгүй мөнхийн рашааны

урсгал хэмээхүй судар оршвой хэмээх энэхүү сударыг Ганданжанзэ цорж гүллэн айлтгаж гандан ширээт Агваанчойнпэл бээр дээдсийн урьд зохиосон судруудаас улбаалан ёнзон багшийнхаа айлдсан жүд дамжлагаар ишлэн норовлинд байдаг өөрийн гэртээ бичив гэжээ.

Цожид буюу тахилын үг Энэтхэгийн хэлээр наму аря дари би буюу хутагт цагаан дарь эхэд мөргөмой. Бурхан бүгдийн үйлсийг нэг дор хураангуйлагч дам үсэг, сарны гэрэл мэт цацарч, илбэчин адил хориг үгүй булгилан гарах, цог эрдмийн үзэсгэлэнт далай төгөлдөр, нас өгөгч, охин тэнгэр мэдэн, цогийг хайрла.

Энэтхэгийн хэлээр наму аря дари би буюу хутагт цагаан дарь эхэд мөргөмой. Бурхан бүгдийн үйлсийг нэг дор хураангуйлагч дам үсэг, сарны гэрэл мэт цацарч, илбэчин адил хориг үгүй булгачилан гарах, цог эрдмийн үзэсгэлэнт далай төгөлдөр, нас хайрлагч, охин тэнгэр мэдэхүйн цогийг хайрла.

Алинбээр нийтийн бус увидасын журамыг бэлэг төгөлдөр, дээдсээс сонсож, анхааран авахын зэрэг, дамжлагын үргэлжлэл, мартахыг огоорон, үсгэн зам дор арвижуулан цацартугай хэмээн бодож тахилын үг өргөмой.

Тэгүүн дор энэ мэт адислан ойртуулж, дамжуулах, нийтийн бус ёсны хутагт охин цагаан дарь эх дор шүтээд насны авшиг айлтгахын үйлэн дор гурваа

1/ ондоо буюу бэлтгэл

2/ ойш буюу бодит зан үйл

3/ жүг буюу төгсгөлийн зан үйл хэмээх болой.

Анх нь ану сэтгэл зохистой газар цагаан дарь эхийн дүр болон зарлиг таалалын аль нэгийг дэлгэн залж, түүний өмнө найман дэлбээтэй мандал тавьж, түүн дээр насны балин буюу сэдэр цагаан навчтайг зохистойгоор байрлуулна. /Бурханаасаа өндөргүй/ түүний баруунд болор болон мөнгөн аяганд чихэртэй сүү хийж насны рашааны бэлтгэнэ.

Рашааны баруун талд зай бүгд нь бүрдсэн насны үрэл ёсчилон бэлтгэж тавина. Түүний өмнө бөөрөнхий цагаан балин, навчтай хийгээд дагжид буюу дүнжидийн 2 устай тахилыг бэлтгэнэ. Ламын өмнө хонх, очир, лай бумба, арвайн сав тэргүүтнийг бэлтгэн тавиад даган буюу бэлтгэл ажил дуусна.

Хоёрдугаар бодит үйлдэхүй дор гурван хэсэгт байна.

1-рт дагжид буюу өөртөө тэнгэрийг үүсгэх

2-рт дүнжид буюу өмнөө тэнгэр үүсгэх

3-рт насны авшиг айлдах лугаа гурав болой.

### **Дагжид буюу өөртөө тэнгэрийг үүсгэх:**

Аврал одуулах өмнийн огторгуйд авралын орон хийгээд, түүнийг тойроод авралын орон цагаан дарь эх залраад, түүнийг тойроод хамаг амьтад заларч байна гэж бодоод уншина.

Би тэргүүд огторгуйн энтэй тэнцэх амьтан бүгд энэ цагаас хойш бодь хутагийг олохыг хүртэл, цог төгөлдөр багш, дээдэс нугуудад авралыг одуулмой. Ялагч, төгс нөгчөгсөн, бурхан дор, аврал одуулмой, дээдийн ном, нугууд дор аврал одуулмой, хутагт хуврага нугууд дор авралыг одуулмой гэж дээрхийг гурав дахин уншина. Багш хийгээд, чухаг дэгээд эрдэнэ гурав дор би бээр мөргөн залбирч аврал одуулмой. Та нугууд бээр надад дамжлагаа адистэдлэн соёрх

### **Бодь сэтгэл үүсгэх ану:**

Хамаг амьтаны тусын тухайд тугуулгасан бурханы утгыг олж, түүний тухайд насны өглөг, Ичинхорлоо, Цагаан дарь эхийн бясгалгал, тарнийг анхааран авч үүлдэе. /Гурав дахин уншина./

Би ямагт нэгэн эгшин бээр хутагт охин, боллоо хэмээн тольт зүрхнээс сарны хот мандалын дээр дам үсэг, цагаанаас гэрэл цацарч, өөрийн орноос багш Цэвэгмид бурханы язгуурын эзэн оршиж, хутагт охин Ичинхорлоо, Цагаан дарь эх дор насны хөтөлбөр, дамжлагын



багш хийгээд бурхан бодьсадва нарын чуулган хүрээлж, өмнийн огторгуй дор залж, **ум базар сама за** хэмээн заллага айлтгаж, **наму гүрү би, наму аря даря, сава, рива ри** хэмээн тарни уншиж чагж хийн, **аргам, байдам, мядаг дүгва мармэ дэчив шалсай** буюу нүүр сэрүүцүүлэх ус, зооглох ус, цэцгэн эрхи, хүж, зул, үнэртэн ус, идээ, хөгжим зэргийг өргөөд,

**гончигсумлай даг жив чи** буюу чухаг дэгээ гурав дор би бээр аврал одуулмой тэргүүтэнийг гурав дахин уншаад

Хамаг амьтан амгалан хийгээд, амгалангийн шалтгаан лугаа  
төгөлдөр болтугай

Хамаг амьтан зовлон хийгээд, зовлонгийн шалтгаан лугаа  
хагацах болтугай.

Хамаг амьтан зовлон үгүй, амгалан лугаа үл хагацах болтугай.

Хамаг амьтан ойр хол, уурлах дурлах хоёроос хагацаж  
тэгш дор оршмой

хэмээх дөрвөөр баясахуй, энэрхүй, асрахуй, тэгш оршихуй гэх энэ дөрвөн цадмид ши буюу цаглашгүй дөрвөн сэтгэлийг үйтгээд

**Ума сава ва шүдо сарва дарма сава ва шүдэ хум** хэмээн хоосон чанарыг хувирч, хоосон чанарын агаараас **бам** үсгээс бадамцэцэг, үсгээс сарны хот мандал үүтгэсний дээр өөрийн сэтгэл ямагт цагаан дам үсгээс гэрэл цацарч, хутагтыг дахиад, амьтаны тусыг үйлдэж, нааш хураагдаж охин тэнгэр, Ичинхорлоо, Цагаан дарь эх, лагшин намрын сар лугаа адил цагаахан, эрдэнийн шилмэт хиргүй тунгалаг, гэрлээр цацарч, нэг нигуурт, хоёр мутарт, гурван мэлмий лугаа төгөлдөр.

Охь үзэсгэлэн төгөлдөр арван зургаан насыг эрхшээгсэн баруун мутраараа дээдийн өглөгийг өгөх, байдлыг үзүүлсэн, зүүн мутраараа цагаан удвал цэцгийн ишнээс чимхэн, зүрхэн тушаагаа барисан нь, гурван цагийн бурхадыг бэлэгдэж, нэг үндэстэй, гурван навчтай, навчнаас гарсан цэцэг дэлгэрч байгаагаар үзүүлсэн, баруун нь үртэй, зүүн нь ургаж байгаа байдалтай цэцэг, тэргүүн дэх гээг юүгээ титэмлэн боосон.

Эх эрдэнийн чимэг элдвээр чимэглэсэн элдэв чимэгт додёог буюу цээжний өмсгөлтэй, улаан торгон шантав буюу хормогчтой, алганы толио болон хөлийн өлмийн нижгээдэд долоон мэлмийг эрхшээсэн.

Сарны хот мандалд лагшин, бат, шүтээд, өлмийн очир

завилгаанд оршиж, түүний оройд цагаан **ум** үсэг, хоолойд улаан **А** үсэг, зүрхэн тушаа сарны хот мандалын дээр цагаан **дам** үсгэнд хөх **хум** үсэг болон хувирч, таалалын хөрөнгөнөөс гэрэл цацарч, өөрийн орноос хутагт охин, Ичинхорлоо, Цагаан дарь эх дор бурхан хийгээд бодь садва нарын чуулган хүрээлээд урин залж, **ум базар сама за - за хум бам хо** гээд дамцагва буюу тангарагтан, шива буюу билэг билгийн мэлмийтэн хоёр бээр ялгалгүй нэгэн агшинд хураагдан дахин түүний тааллаас хөрөнгө, гэрэл цацарч авшигийн тэнгэр, язгуурын тав нөхөр сэлтийг урин залж, тэгүүнчилэн ирэгсэн бурхан бүгд бээр илт авшиг хайрлан соёрх хэмээн залбирал талибаад **ума сарва тата гада, авэ хи гада сама яа ширияа хум** хэмээн зарлиглаад бумба буюу хумхын усаар тэргүүн бээрээ авшигийг өгөөд, лагшин аль бээр хир үгүй ариусч, усны үлдэгдэл бүгд бурхан Цэгмидийн төв дор чимэглэн орших болтугай хэмээн бодоод тахил, нугууд нь **авэхи гада** гэдгээр ариусч, **савава** гэдгээр харшлах шалтгааныг хөөж, хоосон чанарын араас **бүрэм** үсэг их эрдэнийн сав дүүрч түүн дотор **ум** үсэг гэрлэн дор хувирч, тэнгэрийн зайгаар бүтээсэн, **чодёон шавсал** хэмээх хоёр ус, **мядаг** хэмээх цэцэг, **дугвой** хэмээх хүж, **мармэ** хэмээх зул, **дэчив** хэмээх үнэртэй ус, **шалса** хэмээх идээ зоог **оролмаа** хэмээх хөгжим, зэмсэг, жигдрэн өмнийн огторгуйн энтэй адил цувиралтгүй, амгалан ялгамжаатайг үүсгэсэн дор болгоод **аргам, байдээм, бүйвий, дүйвий, алоги, ганди, нэвди, шавда** хэмээх хүртэл адистэдэлмой.

Өөрийн зүрхнээс цацарсан, тахилын тэнгэр нугууд бээр тахиж байна хэмээн бодоод **ум аря даря сава рива ри аргам, байдэм, бүйви, дүйви, алогэ, ганди, нэвди, шавда** хүртэл тахимой.

Алинбээр таны өлмий лянхуад бишрэн тахиснаар дари тэргүүний язгуурын тарни төдий тоолсноор үхэл үгүй наст, билэг билгийн буян тэргүүтэн, юу санасныг илт бүтээн хайрлахуй дор мөргөмөй хэмээн магтан тэнгэрийн лагшин, хоосон чанар ялгалгүй хэмээн сэтгэлээ тушаасан төдий оронд тэгш агуулаад

Би ямагт хутагт охин Цагаан дарь эхэд тодорсоны зүрхэн тушаа найман хигээстэй цагаан хоролын голд гурав давхарласны дээр хүйсэнд сарны дээр өөрийн сэтгэл цагаан **дам** үсгийн эцэст **ум** үсэг хийгээд **ха** үсэг хүртэл багтаан тойруулж, эргүүлээд найман үзүүрт **да ри ду да ри дү ри суха** хэмээх найман үсэг тасралтгүй дотроосоо **ма ла ай ли** үсгээс эхлэн буруу эргэж дунд дор **гай ли**

үсэг нь зөв эргэж гадна талд шүтэн барилдлагааны шим зөв эргэж, хөрөнгө үсэг бүгдээс гэрэл рашааны мөн чанараар цацран, үсэрч очлоод, өөрийн оройд язгуур бие, бурхан Цэвэгмид, лагшин улаан нэг нигуурт, хоёр мутар бээр алтан хумханд үхэлгүй насны рашааны үргэлжлэл дүүргэн тэгш агуулан барьж, торго хийгээд эрдэнийн чимгээр чимэглэн, өлмийн очир завилгаан бээр оршиж, тааллын хэрээ үсэг улаанаар билэгдэн, тэгүүнээс улаан гэрэл цацарч, гох адил арван зүг дор цацраад өөрийн нас хүн хийгээд хүмүүн бус нугууд бээр булаагдаад, хулгайлагдаад хаягдаад, алдагдсан бүгд лугаа их таван аясын сэтгэл, амьтан бүгдийн нас хийгээд буян, гурван орчлонгийн сэвжид жавхлан тэргүүт, орчлон ертөнцийн цог учрал, өлзий хутагт бүрдсэн бүгд хийгээд, багш бурхан нөхөр лугаа сэлт лагшин, зарлиг, таалалын адистэд бүгд өнгө, зохис элдэв чуулганы рашааны гэрэл лугаа сэлтийн байдал дор хураагдан татагдаад мутрын бумбаны дотор шингээд, шингэснээс нь цагаан рашааны дусал гарч, миний оройн шар усны нүхэнд оршоод, зүрхний хорол тархины эрхи, хөрөнгө сэлт лугаа шингээд, дотор бүхэнд дүүрээд, гадагш бүгдийг угаах, тэргүүлэшгүйгээс хураасан хилэнц, түйтгэрийн өвчин, ад, барцад, сэлт бүгдийг ариусгаад нас буян, сахил санваар бүгдийг сэргээн, үхэлгүй насны шийдэх бүтээлийг олох болтугай хэмээн залбирч бодоод **ум да ри дү дари дү ри мама аюу бү ни за на бус там гү рү суухай** хэмээх тарнийг тоолж дахин зүрхний тарнийн хорлоос цагаан гэрэл цацарч, цайвартан туяарч, шар усны нүх болгоноос гадагш гарч, биений гаднаас цагаан гэрэл цацарч, орон гэр бүгдээр эргэлдэн, амгалангийн үйл бүгд бүтэж байна хэмээн бодно.

Бас шар гэрлийн чуулган цацарч, бие дүүрч, нас хийгээд буян дуудах, санах, бясалгах гурвын ухаан тэргүүнийг дэлгэрүүлэн үйлдэж, гадагш цацарч, гэр орны мухар өнцөг бүрт цагаан гэрэл, шар гэрлээр эргэлдэн тойрч, дэлгэрүүлэлтийн үйл бүхэн бүтэж байна гэж бод.

Бас улаан гэрлийн чуулган цацарч, гурван орчлонг эрхэндээ хурааж, хүч лугаа төгөлдөр болоод, гадагш цацарч, шар гэрлийн эцэс нугуудыг улаан гэрлээр хүчлэн сэлгэж, гэр орныг тойрон хүрээлэн, эрхэндээ авах үйл бүгд бүтэж байна. хэмээн бод. Бас хөх гэрлийн чуулган ч цацарч, урдын үйлдсэн үйл бүгдийн бүтээх хүч лугаа төгөлдөр болж, гадагш цацарч улаан гэрлийг нэхэж, хар хөх

гэрэл хүчтэйгээр орон гэрийг тойрч, хатуу үйл бүтээн байна хэмээн бод.

Бас ногоон гэрлийн чуулган цацарч, үйл огоот, уужим бүгд бүтэхүй дор эрхшээж, гадагш цацран, хар хөх өнгийг эцэслэн, ногоон гэрэл орон гэрийг тойрон эргэлдэж огоот, уужим бүгд бүтэж байна хэмээн бод.

Бас ногоон гэрэл цацран үйл хийгээд илт бүтээл бүгдийн хүч, бат оршиж, гадагш цацран ногоон гэрлийг эцэслэн элэгний өнгө бээр гэр орныг дүүрэн эргэлдэж, гэрлүүд орон байшин бүгдэд буй гэрэл бүгд өндөгний хэлбэртэй, жижиг жижиг нэг дор хувираад, нарийнаас нарийн болж нягтраад салхи ч орохгүй хүчтэй, завсар бүгдээс нь хөх удвал цэцэг шинэхэн уруул мэт үзэсгэлэнтэй гэж бодож бясалга. Цааш нь дэлгэрүүлбэл бас зүрхний тарнийн хорлоос гэрэл цаглашгүй арван зүгт цацарч, зургаан гэрэл нэгдэн нийлэж гадна талд тойрон, орчин, газар, хашаа, лавир, сэлт лугаа хамгаалахын хорол бээр, зүг бүхэн завсар үгүй тойрсон байна хэмээн бод,

Би ямагт хутагт охин болсон хэмээхээс эхлэн гэр орон зургаан тасалгаат бясалгалаар хамгаалах очир хүртэл сэтгэлээ шулуун барьж, тарни, тогтоол, салхи барих тэргүүнийг дээдсийн увидас лугаа адил үйлдсэний дараа Доржсэмбэ бурханы игжа уншиж үйлд.

**Магтаал ану:** Буян энэ бээр түргэн надад бурхан Ичинхорлоо Цагаан дарь эх бүтсэнээр амьтан бүгдийг нэгийг ч хоцроолгүй бурханы оронд оршоох болтугай.

## **2-рт Дүнжид буюу өмнөө бүтээж үйлдэхүүн тухайд:**

Эхлээд ариун ус бүтээх хэрэгтэй. Түүний ёс ану: лай бумбан дотор наран дэвсгэр дээр **хум** үсгийн тарни эргэлдэн гэрэл цацарч, арван зүг бурхан бодьсатва бүгдийн адистэдийн хүчээр гэрлийн байдалтай урин залж, **хум** үсэг тарнийн эрхи лугаа сэлт дор шингээд түүнээс рашааны үргэлжлэл хальж, бумбын усанд шингэлээ гэж бодоод **ум базар амирида гүн да ли, хана хана хум пад** хэмээн уншсаны дараа **хум** үсэг тарнийн эрхи сэлт, гэрэлд хайлаад бумбын усанд шингэлээ хэмээн бод.

### **Дүнжидийн тахил адислагаа:**

Бумбаа сагнаад **ум базар амирида, гүн дали, хана хана хум пад хэмээн ариусч ума савава шүдо сарва дарма савава шүдо хум** хэмээн тотгорийг арилгаад хоосон чанарын агаараас өөрийн өмнө бадамцэцэг, саран дэвсгэр дээр **дам** цагаан үсэг огоот хувираад, балин хоёр үгүй хутагт охин гэтэлгэгч Ичинхорлоо, Цагаан дарь эх хэмээхээс Бангүжадав хүртэл дагжид хийгээд тахилын тарни нугуудыг өргөсөн болой.

### **Магтаал:**

Хутагт охин таны алдрыг дуулах төдийд л  
Хүчит үхлийн эзэн, эрлэгийн элчийг ялан зохиогдох  
Хийгээд үхэл үгүй насны илт бүтээлийн дээдийг  
Хайрлагч, үзэсгэлэнт Цагаан дарь эхийн өлмийд мөргөмөй.

### **Дүнжид эхлэхүй:**

